

**ЗҮҮН ӨМНӨД АЗИЙН ОРНУУД
ХОРШИН ХӨГЖСӨН НЬ**
(Туршлага, сургамж)

Ч. Сувд*

Манай улсад өөрчлөлт шинэчлэлт хийхэд юуны өмнө саяхан болтол манайхтай нийгэм, эдийн засгийн хөгжлөөр адил төвшинд байсан, ард түмний ахуй амьдрал, зан заншлаараа ойр төстэй Азийн орнуудаас суралцах, ололт туршлагыг нь судлах явдал чухал ач холбогдолтой билээ. Харин эдгээр орны хөгжилд нөлөөлсөн хүчин зүйл олон боловч ЗӨА-ийн нэлээд улс орныг нэгтгэсэн «Зүүн Өмнөд Азийн орнуудын холбоо» (АСЕАН)* онцгой үүрэгтэй юм. Ер нь аливаа орны хөгжилд дэлхийн ба бүс нутгийн аж ахуйн нэгдмэл системд оролцож, хөдөлмөрийн хуваарьт тодорхой байр эзлэн, үйлдвэрлэлээ хорших, төрөлжих, дагнах асуудал чухал байдгийг тус холбооны гишүүн Индонез, Малайз, Сингапур, Тайланд Филиппин, Брунейн туршлага тод харуулж байна. АСЕАН нь дэлхийн аж ахуйн системд, ялангуяа Ази, Номхон далайн орнуудын хамтын ажиллагаа, сайн хөршийн харилцаанд чухал үүрэг гүйцэтгэдэг эдийн засаг, улс төрийн томоохон хүчин билээ.

Гишүүн орнууд нь хүн ам, нутаг дэвсгэрин хэмжээ, газарзүйн байршил, шашин шүтлэг, төрийн байгууламж зэргээрээ харилцан адилгүй боловч ЗӨА-д оршдогоороо, Хөгжлийн эрэлт хэрэгцээгээрээ ойролцоо зэргээс хамааран нэгдэж АСЕАН гэдэг олон улсын нэр хүндтэй байгууллага бий болгож, улс орноо хөгжлийн харьцангуй өндөр төвшинд хүргэж байна.

а) **Хамтын ажиллагаа.** Тус холбоо байгуулагдсан даруйдаа эдийн засгийн салбарт:

а) суурь салбарын, ялангуяа эрчим хүч, хүнсний салбарын илүүдэл бүтээгдэхүүнийг бие биендээ тэргүүн ээлжинд нийлүүлж, гол нэр төрлийн бүтээгдэхүүний хомстлоос гарах.

б) томоохон хэмжээний объект байгуулах, орон нутгийн материал өргөн ашиглах, гадаадын хөрөнгө оруулах, түүнийг хэмнэх, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх,

в) худалдааны харилцааг чөлөөтэй болгох,

г) олон улсын эдийн засаг, худалдааны харилцаанд орохдоо нэгдмэл байр суурь баримтлах гэсэн 4 чиглэлээр хамтын ажиллагаагаа идэвхжүүлж иржээ. Үүний дотор худалдааны харилцаа нэлээд өргөжиж, хураамжаас чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх, хязгаарлалт тавихаа багасгах зэргээр хамтран ажиллаж эхлэв. Гаалийн тааламжтай нөхцөл нь гишүүн орнуудын гадаад харилцааг бүхэлд нь бүс нутгийн дотоод харилцааг жичид нь идэвхжүүлсэн юм.

б) **Аж үйлдвэржүүлэлт** Гишүүн орнуудын үйлдвэржилт гүнзгийрч, материал, хөдөлмөрийн багтаамжит салбараас оюуны зарцуулалт ихтэй, нарийн хийц, технологи бүхий салбаруудыг түлхүү хөгжүүлэв. Энэ бүхний үр дүнд үйлдвэржилтэд нь салбарын болон бүтцийн өөрчлөлт

*Дорно дахин, олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан.

-Зүүн өмнөд Азийн улсуудын холбоо байгуулагдахаас өмнө тус байгууллагын гишүүн орнууд хөгжлийн төвшнөөр дорой, дэлхийн аж ахуйн харилцаанд ороогүй, бусад улс орны сонирхлыг татдаггүй байв. Харин одоо тус Холбоо нь олон улсын тавцанд нэр хүндтэй гишүүн орнууд нь шинээр аж үйлдвэржсэн орнууд гэгдэх боллоо.

гарчээ. Үйлдвэржүүлэлтийн бас нэг гол онцлог бол хүнд ба хөнгөн аж үйлдвэрийн харьцааны өөрчлөлт бөгөөд хөнгөн үйлдвэрээс хүнд үйлдвэрт шилжих процесс явагдаж байна. Тухайлбал боловсруулах үйлдвэрийн бүрэлдэхүүнд хүнс, тамхины уламжлалт салбарын хувийн жин аажмаар буурч, нэхмэл, савхин эдлэл, нефть, хими, машин, металл боловсруулах үйлдвэрийн хувийн жин мэдэгдэм нэмэгдэж, үндэсний эдийн засагт нь байр сууриа оллоо.

Жараад оны үед гишүүн орнуудын үйлдвэржүүлэлтийн эцсийн үр дүн хэрэглээний зүйлсийн үйлдвэрлэлээр тодорхойлогдож байсан бол одоо завсрын болон эцсийн бүтээгдэхүүн, удаан эдэлгээтэй ба хөрөнгө оруулалтын зориулалтаар ашиглах бүтээгдэхүүний үйлдвэрлэл зонхилох болов. Гэхдээ Сингапураас бусад орны аж үйлдвэржүүлэлт нь хөгжингүй капиталист орнуудынхтай харьцуулахад доогуур, бүтцийн өөрчлөлт бүрэн явагдаагүй, шилжилтийн шинжтэй байгаа нь илэрхий. Гэвч эл байдал нь дээрх орнуудын үйлдвэржүүлэлтийн туршлагыг үнэлэхэд өчүүхэн ч саад болохгүй билээ. Учир нь:

1) Эдгээр орон аж үйлдвэрт зориулан хөрөнгө оруулаад зогсохгүй түүнийгээ нэмэгдүүлж байгаагийн үрээр хөрөнгө оруулалтын хэмжээч, үр ашиг нь ч дээшилсээр ирэв;

2) Оюуны багтаамж бүхий салбарын хөгжилд ихээхэн анхаарал тавьсан нь тэдгээр орны үйлдвэржүүлэлтийн нэгэн содон шинж мөн.

3) Үйлдвэржүүлэлт нь хөдөө аж ахуйн салбарынхаа хөгжлийг сааруулсангүй.

4) Тухайн орнууд импорт орлох бараанд ихээхэн анхаарал тавьсны ачаар зах зээлийн дотоод багтаамжаа нэмэгдүүлж, гадаад худалдааны чиглэлээ ихээхэн өөрчилж чадсан юм.

5) Үйлдвэржүүлэлтийг дагалдан хотын хүн ам, тэр дундаа ажилчин ангийн эгнээ түргэн өсөж, эдийн засгийн идэвхтэй хүн амын нэлээд нь үйлдвэр, үйлчилгээний салбарт ажиллах болсон нь зөвхөн ажил эрхлэлтийн өөрчлөлтийг илэрхийлээд зогсохгүй нийгмийн бүтцэд гарсан өөрчлөлтийг давхар харуулж байна.

6) Гишүүн орнуудын хөгжлийн хурдац хөгжиж буй орнуудтай харьцуулахад өндөр ч, түрүү үеийнхээсээ саарах төлөвтэй байна. Ялангуяа наяд оны дундуур дэлхийн эдийн засгийн хямралтай уялдан уналтад орсон авч сүүлийн жилүүдэд сэргэснээс үзэхэд тухайн орнуудын үндэсний нийт бүтээгдэхүүний хурдац саарсан ч эдийн засаг нь ерөнхийдөө бэхжиж, нуралт бууралтаас түргэн гарах чадавхитай болсныг тэмдэглүүштэй.

в) **Хөдөө аж ахуй** бол гишүүн орнуудын үндсэн бөгөөд шийдвэрлэх ач холбогдол бүхий салбар юм. Малайзын эдийн засгийн идэвхтэй хүн амын 45,4 %, Филиппиний 43,9%, Тайландын 73,9% Индонезийн 56.5% нь хөдөө аж ахуйд ажиллаж байгаа бөгөөд гол төлөв газар тариалан эрхэлдэг. Эдгээр орон **1-рт**, урин дулаан цаг уур, ургамлын сан хөмрөг зэрэг давуу талдаа тулгуурлан хөдөө аж ахуйгаа өөд татан томоохон амжилтанд хүрч байна. Түүний тодорхой үзүүлэлт нь хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг үйлдвэрийн аргаар боловсруулах төвшин ахисан явдал юм.

2-рт, Хөдөө аж ахуйн салбарт нь өмчийн олон хэлбэр зэрэгцсээр иржээ.

3-рт, Аж үйлдвэржүүлэлт нийтлэг шинжтэй бол, хөдөө аж ахуй нь алаг цоог байдалтай байгаа бөгөөд аль нэг салбар нь өрөөсгөлдүү хөгжсөн байдаг.

4-рт, Хүн ам хотшин шилжих хөдөлгөөнд хамрагдаж эхэлсэн нь мэдээж, гэхдээ манай орон шиг хэт олноороо шилжиж, уг салбар нь ажиллах хүчний дутагдал, гачаалд ороогүйгээрээ бас ялгагдана. Энэ бү

хэн бол АСЕАН-ы орнуудын хөдөө аж ахуйн хөгжлийн туршлага ч, сургамж ч болж байна.

г) **Гадаад худалдаа.** Үндэсний зах зээлээ дэлхийн эдийн засагтай холбохын тулд 1-рт, чөлөөт худалдааны бүс байгуулах, 2-рт, гаалийн холбоо байгуулах, 3-рт нийтийн зах зээл бий болгох, 4-рт, эдийн засгийн холбоо байгуулах хэлбэрийг ашиглаж ирэв. Хамтын ажиллагааны эхэн үед нэг, хоёрдугаар хэлбэрийн харилцаа голлож байсан бол 80 аад оноос гурав, дөрөв дэх хэлбэрийн харилцаа, түүнд тохирсон уян хатан механизм зонхилж байв. Гишүүн орнуудын эдийн засагт гадаадын хөрөнгө оруулалт улсын ба хувийн замаар нэвтрэх нь ихсэж, бас тэгээд тогтвортой байснаараа онцлог юм. Энэ нь дээрх орнуудад гадаадын капитал орж ирэх үүд хаалгыг нээгээд зогсохгүй хөрөнгө оруулалт хийх таатай нөхцөлийг тал бүрээс нь бүрдүүлж өгч байгаатай холбоотой.

АСЕАН-ны орнууд гадаад харилцаагаа хөгжүүлэхдээ бүс нутгийнхаа эрх ашгийн үүднээс дотоод бодлогодоо импорт хэмнэх, импорт орлох талаар ихээхэн анхаарал тавьж байгаагийн зэрэгцээ гадаад бодлогодоо өөрсдийн түүхий эд, аж үйлдвэрийн зарим бүтээгдэхүүнийхээ дэлхийн зах зээлд борлогдох, өрсөлдөх чадварыг хамтран хамгаалж, зарим нөхцөлд эрс тууштай, хатуу байр суурь баримталж буй нь анхаарууштай зүйл юм. Энэ бүхнээс үзэхэд гишүүн орнууд, хөгжингүй капиталист орнуудын хоорондын харилцаа өргөжиж, тэдгээрийн хооронд бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, чанарын үзүүлэлтээ сайжруулах өрсөлдөөн улам бүр ширүүсэж байна.

Тухайн орнуудын гадаад харилцааны гол туршлага бол нээлттэй эдийн засгийн бодлогыг тууштай баримталж, дэлхийн аж ахуйн системтэй ойртон нэгдэж, үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцож буйд оршино. Үүний тулд:

- экспорт голлосон үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлж, экспортоо нэмэгдүүлж байх;
- импорт хэмнэх юм уу орлох зарчмыг чанд баримтлах;
- гаалиас эхлээд хамтын үйлдвэр барих хүртэлх зохистой нөхцөлийг бүрэлдүүлэх;
- холбоо болон оролцогч орнуудынхаа эрх ашгийг тууштай хамгаалах;
- бүс нутгийн хийгээд тодорхой бүтээгдэхүүнийг зонхилон экспортлогч, импортлогч улсуудын сайн дурын байгууллагад нэгдэх буюу тиймэрхүү байгууллагыг үүсгэх, нэгдэн орох;
- холбооны гишүүн орнуудтайгаа гадаад харилцаагаа өргөжүүлэхийн хамт шаардлагатай үед гадаад харилцааны чиглэлээ өөрчлөх чадвартай байх;
- зах зээлээ нэг орон юм уу, нэг байгууллагаас хараат бус байлгах
- буцах, дамжих экспорт, импорт эрхлэх болсны үр дүнд экспорт, импортынх нь квот ихээхэн өөрчлөгджээ.

АСЕАН-ны орнуудын эдийн засгийн амьдралд сүүлийн үед гарсан нэг үзэгдэл бол хувьчлал юм. Хувьчлал нь орчин үеийн эдийн засгийн амьдралын нийтлэг, түгээмэл шинж төлөв, үйл явцын тусгал болохын сацуу орон тус бүрийн онцлог, өвөрмөц шинжийг давхар илэрхийлж байна.

Өмч хувьчлал орон бүрд харилцан адилгүй явагддаг боловч дараах үндсэн хандлага харагдаж байна. Үүнд: засгийн газрын үүрэх санхүүгийн ачааллыг багасгах, улсын секторын үр ашгийг дээшлүүлэх, улсын бус хөрөнгө оруулалтыг ашиглах замаар хөгжлийг түргэтгэх; улсын Монополь, хүнд суртлыг арилгах, капитал үнэт цаас, валютын зах зээл бий болгох; гадаад өр зээлд хүлээх хариуцлагыг засгийн газар, чөлөөт

үйлдвэрлэгчид хуваах; чөлөөт үйлдвэрлэгчдийг дэд бүтэц, боловсрол зэрэг засгийн газрын уламжлалт салбарт татан оролцуулах, эд бүгд орох болно.

Өмч хувьчлахын гол утга учир бүрэлдэн буй зах зээлийн нөхцөлд улсын монополь, өрсөлдөөний хамгийн ашигтай харьцаа тогтооход оршино. Зах зээл хөгжсөн нөхцөлд таваарын үнэ, түүний шаардлагатай тоо хэмжээ эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрээс хамаардаг нь бүхэнд илэрхий. Гэхдээ үнэ нь үйлдвэрлэгчийн ашгийг хангахын тулд үйлдвэрлэлийн зардлаас дээгүүр байх ёстой.

Хувьчлах ажлын зохион байгуулалт нь:

1. Хэсэгчилсэн байдлаар хувьчлалыг явуулж байна.
2. Зарим орон хувьчлалыг зохион байгуулахдаа нэлээд эрх мэдэл бүхий улсын хороо байгуулсан байхад Малайз мэтийнх нь хувьчлалд хоёрдугаар зэргийн ач холбогдол өгч, улсын өмчийг голчилж байна.
3. Хувьчлалыг яаруу сандруу бус, нэлээд хугацаанд туршилтын журмаар эхэлж, улам бүр лавшруулан, хүрээг нь тэлж байна.
4. Боловсон хүчний чанар, санхүүгийн бэл бэнчин, өөрийн орны онцлог зэргийг нэлээд бодитойгоор үнэлэн цэгнэж, зохих ёсоор хадгалж байна.
5. Хувьчлалыг хэрэгжүүлэхдээ:
 - а. хувьд өгсөн тохиолдолд ашигтай байх нь баталгаагүй, аз турших төлөвтэй бол улс эзэмшилдээ үлдээж, дараа нь эзэнд нь өгөх болзолтойгоор удирдлагын мэдэлд олгох;
 - б. улсын үйлдвэр, хувь нийлүүлэгчдийн хамтарсан хувьцааг шууд худалдах, өөрөөр хэлбэл, улс үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд шууд оролцоггүй, гэхдээ хяналтаа тавьсаар байх;
 - в. үйлдвэрлэлийг бүхэлд нь юм уу хэсэг хэсгээр нь, нэг юм уу хэд хэдэн хуулийн этгээдэд, тухайлбал, үнэ хаялцуулан өгөх;
 - г. улсын үйлдвэрийг татан буулгаж, шууд хувьд өгөх;
 - д. шууд бусаар хувьчлах, тодруулж хэлбэл, улсын өмчийн монополийг хязгаарлах, зээллэг болон татварын хөнгөлөлт үзүүлэх;
 - е. түрээсийн хугацаа дуусахаар хувьд нь өгөх гэсэн зургаан хувилбарыг ашиглаж байна.

Манай орны хувьд дээрх холбооны орнуудын зарим туршлага, тухайлбал, НҮБ-аас мэргэжилтнүүд урьж хөгжлийн программ боловсруулах, экспортын чиглэлээр үйлдвэрлэлээ хөгжүүлж, бүтцийн өөрчлөлт хийх, импорт хэмнэх бодлого баримтлах зэрэг туршлагаас суралцаж болох юм.